

Манмин Мэдээ

№ 32 2013 оны 3-р сарын 3

Таныг сүнс, сэтгэлээр өсөхөд илүү ойрхон GCN (Жи Си эн) телевиз Дэлхийн 170 гаруй орны үзэгчидэд зориулсан Христчин телевиз.



GCN (Жи си эн) телевиз нээгдсэн тэр өдөр GCN (Жи си эн) телевизийн төв байрлаж байгаа Empire (Импаяр) Төв Барилгын дээр тэнгэрт гялалсан, гайхалтай сайхан загалмай үзэгдсэн билээ.

Өнөө үед хүмүүс хиймэл дагуул, кабелийн телевиз, интернет, IP телевиз, ухаалаг гар утас гэх мэт хэт өндөр хурдтай хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлийн эрин үед амьдарч байна. Маш олон төрлийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл болон нэвтрүүлгийн тоо тогтмол өссөөр байгаа ч үзэгчдэд ашигтай, сургамж болох сайн чанарын нэвтрүүлгийг олж, сонгон үзэхэд нэн бэрхшээлтэй болжээ.

Яг энэ л үед хүмүүст аврал, гайхалтай эдгэрэл, өөрчлөлтийг авчирч, цаг үед нь тохирсон хөтөлбөрийг нэвтрүүлж, ивээл ерөөл рүү хөтөлдөг нэгэн телевиз бий. Энэ бол Бурханы хайр ба эрх мэдэлт хүчит үйлсүүдийг дамжуулдаг GCN (Жи си эн) хэмээх Христчин телевиз юм. GCN (Жи си эн) телевиз (Захирал доктор И Жейруг пастор, вэбсайт: www.gcntv.org) нь зөвхөн Гурвын холбооны Бурханы алдрын төлөө бүх улс орны ард түмэнд номлол, сургаалыг цацаж, нэвтрүүлэхийн тулд байгуулагдсан телевиз юм.

Манай телевиз энэ дэлхийд өвчин зовлонгоос гадна өөр олон хүнд асуудлуудаас болж зовж шаналж

байгаа үй олон хүмүүст үнэний гэрлийг таниулж өгөх төдийгүй Мөн Бурхан амьд оршин буйг ба Есүс Христ бол бидний аврагч болохыг нотолж буй үй олон эрх мэдэлт хүчний үйлсүүдийг бүх ард түмэнд болон тунхагладаг билээ.

Телевиз үзэгчидэд олон төрлийн өргөн сонголттой нэвтрүүлэг, хөтөлбөрөөр үйлчилдэг ба Үүнд: Доктор И Жейруг тэргүүн пасторын “Амийн үг” сургаалийн нэвтрүүлэг, үзэгчид болон итгэгчдийн ивээл дүүрэн гэрчлэл ба Ариун библийн үгс чин үнэн болохыг бататгаж буй “Эрх мэдэлт хүчний нууц”, “Угийн дуу хоолой” гэх мэт гэрчлэл ба танин мэдэхүйн нэвтрүүлэгүүд, мөн И Сү жин пасторын GCN (Жи си эн) телевизийн цуврал сургаал “Би хэрэгжүүлнэ” нэвтрүүлэг болон “Магтаал ба Хүндэтгэл” гэх зэрэг бусад телевизүүдээс огт өөр шинэлэг болон ялгарч чадахуйц нэвтрүүлгүүдийг дамжуулдаг билээ.

Мөн түүнчлэн GCN (Жи си эн) телевиз нь Солонгос, Англи, Испани, Орос, Франц, Урду гэх мэт олон орны хэлээр нэгэн зэрэг орчуулж нэвтрүүлгээ цацах хүчин чадалтай

ба ингэж олон орны хэлээр орчуулж байгаа нь бусад орны үзэгчид үзэхэд ямар ч асуудалгүйгээр ойлгох боломжтой болж байгаа юм.

Хөтөлбөрүүдийн дундаас хамгийн чухал бөгөөд ивээлтэй нэвтрүүлэг нь Доктор И Жей руг тэргүүн пасторын “Амин үг” хэмээх сургаалийн нэвтрүүлэг юм. Түүний үндсэн сургаалууд болох “Загалмайн утга учир”, “Итгэлийн хэмжээ”, “Тэнгэрийн орон”, “Там”, “Ариун Сүнсний есөн үр жимс”, “Хайрын бүлэг” гэх мэт сургаалууд нь дэлхий дахинд цацагдсаар байна.

Мөн 2013 оны 1-р сарын 1нээс дижитал телевизээр дамжуулах бэлтгэл ажил хийгдэж, GCN (Жи си эн) телевиз нь техник технологийн өндөр түвшинд (HD) сургаалын нэвтрүүлгийг бэлтгэн гаргах ажлаа эхлээд байна. Техник технологийн өндөр түвшинд хийгдсэн энэхүү HD нэвтрүүлэг нь дуу дүрсний өндөр чанартай нягтрал сайтай тул өдөрт 3 удаа цацагдаж буй Доктор И Жей руг тэргүүн пасторын сургаалууд болон ялангуяа “Өвчин эдгээх залбирал”-р дамжуулан олон хүмүүс Есүс Христийг хүлээн авч, Христчин

амьдралаар амьдарч, цаг, орон зай даван гарсан Бурханы эрх мэдэлт хүчийг улам бүр мэдэрсэн үзэгчдийн гэрчлэлээр бялхан байна.

Мөн цаашлаад үзэгчид Манмин Төв Сүмийн бүх мөргөлүүд, Даниел залбирал болон өөр олон төрлийн хөтөлбөрүүдтэй утсаар болон интернэтээр холбогдож хүлээн авах боломжтой. Мөн гар утас (ухаалаг гар утас) хэрэглэгчид 24 цагийн турш m.gcntv.org-г холбогдож чөлөөтэй хэрэглэж болно.

GCN (Жи си эн) телевиз нь дэлхий бусад NRB Network, Enlace Rodnoy TBN, CNL гэх мэт дэлхийн бусад хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлүүдтэй хамтран ажиллаж байна. Мөн түүнчлэн олон нийтийн телевизийн станц, хиймэл дагуул, кабелийн телевизүүдээр дамжуулан ойролцоогоор 170 гаруй оронд хөтөлбөрүүдээ цацаар байна. Тиймээс хүмүүс хэзээ ч, хаана ч үзэх боломжтой юм. Шинэ жилдээ 2013 онд Бурханаас хариулт болон ивээл ерөөл дүүрэн авахын тулд олон хүмүүс үүнийг хүсэн тэмүүлсэн зүрх сэтгэлээр үзнэ гэдэгт бид бүхэн итгэлтэй байна.

Эцсийн үеийн авралын зорилго.

“Бурхан бүх хүмүүсийг аврагдаасай, үнэний мэдлэг рүү ирээсэй гэж хүсдэг” (1 Тимот 2:4).

Бурхан бол хайр тиймээс Тэр бүх хүмүүсийг энэ дэлхийд амьдарч буй долоон тэрбум хүнийг жинхэнэ үнэнийг мэдээд хүрээд ирээсэй, ариун зарыг сонсож, аврал аваасай гэж үнэхээр их хүсдэг. Эцсийн үеийн авралын зорилго гэдэг нь Бурхан болж л өгвөл үй олон хүнийг аврахыг хүсэн тэмүүлсэн Түүний төлөвлөгөө юм. Тийм учраас 2013 онд бид бүхэн эцсийн үеийн авралыг авч, бүрэн төгс гүйцэлдүүлж, зүрх сэтгэлээ ариусгахын тулд юу хийх шаардлагатай вэ?

1. “Манмин” хэмээх нэрэнд Бурханы агуу гайхамшигт хайр агуулагдсан байдаг.

Бурхан Аав аврал өгөхийг хүсч байгаа хайрын сэтгэлээ “бүх үндэстэн, бүх ард түмэн” гэсэн утгатай “Манмин” сүмээр дамжуулан илчлэн харуулахаар шийдсэн. Тийм учраас Тэр энэ сүмийг “Манмин” гэж нэрлэсэн. Би Бурханы дуудлагыг аван 37 настайдаа библийн сургуульд орсон тэр үеэс буюу 1-р дамжаанд байхаасаа эхлэн сүмийг нээх бэлтгэл ажил эхэлсэн юм. Бурхан Аав Өөрөө энэ сүмд нэр өгөхийн төлөө би Түүнд онцгойлон залбирдаг байлаа. Гэтэл яг гурван жилийн дараа, сүмээ байгуулаад нэг их удаагүй байтал Бурхан миний залбиралд хариулж “Манмин гэж нэрлэ” хэмээн айлдсан юм.

Эцсийн үеийн авралын зорилгыг биелүүлэхийн тулд Тэр энэ сүмийг босгон байгуулж ‘Манмин Сүм’ гэж нэрлэсэн юм.

Сүм байгуулагдсаны эхний хэдэн жил бид ‘Манмин Сүм’ гэж нэрлэж байгаад цаашдаа салбар сүмүүдтэй болсон тул ‘Манмин Төв Сүм’ гэж нэрлэсэн. Одоо манай сүм 10,000 гаруй салбар сүм болон хамран ажиллах сүмүүдтэй болсон билээ.

Энэ мэт гайхамшигт авралд зөвхөн Манмины гишүүд ч биш, дэлхийн бүх хүмүүс Бурхан Аавын зүрх сэтгэлд аль хэдийн өвөрлөгдсөн байсан юм. Одоо Бурхан Аавын зүрх сэтгэлд хадгалагдсан байсан эцсийн үеийн авралын зорилгыг чин зүрхнээсээ хэлэх, ил гаргах цаг нь болжээ. Ийм учраас Бурхан Аав маань өнөөдрийг хүртэл урьдчилан бэлтгэлийг хийсээр байгаа билээ. Энэ зорилгыг жинхэнээсээ биелүүлж, бүх хүмүүсийг аврахын тулд маш том сүнслэг дайн эхлэх юм.

Чадварлаг, туршлагатай жанжин тулалдаан эхлэхийн өмнө дээд зэргийн бэлтгэл хангаж, тулаанд бэлддэг. Хамгийн нэгдүгээрт чи маш сайн зэр зэвсэгтэй байх шаардлагатай. Мөн танай цэрэг дайчид чинь маш сайн сургуулилт хийж, сайн бэлтгэгдсэн байх шаардлагатай. Тэд зэр зэвсгээ чадварлаг эзэмшсэн байх хэрэгтэйгээ гадна байлдааны бодлогыг сайн ухаарах чадвартай байх хэрэгтэй. Мөн түүнчлэн дээд удирдлага, дарга нарынхаа тушаалыг дуулгавартай дагахад бэлэн байх чадварыг эзэмших хэрэгтэй. Энэ нь армийн сахилга бат маш сайн, дэг журамтай байх хэрэгтэй гэсэн үг. Хамгийн чухал зүйл нь цэрэг дайчид тулаанд ялж, ялалт байгуулна

гэдэгтээ бүрэн дүүрэн итгэлтэй, зоригтой байх явдал юм. Сүнслэг дайн ч мөн яг үүнтэй адилхан. Хүмүүсийг аврахын тулд чин зүрхнээсээ хүсэн тэмүүлж, эцэсээ хүртэл өөрийгөө бэлдэх хэрэгтэй (Эфэс 6:12-13).

2. Эцсийн үеийн авралын зорилгог хүрэх Бурханы бэлтгэл.

1) Нэгдүгээрт, Бурхан хүмүүсийг аврахын тулд биднийг дээд зэргийн түвшинд бэлтгэхийн тулд ажиллаж байна.

Олон хүмүүсийг аврахын тулд хамгийн чухал шаардлагатай багаж хэрэгсэл нь юу вэ? Энэ бол Эфэс 6:17-д бичигдсэн дайсан Сатан диаволыг уруу татлага ба хорт үйлсийг устгах ‘Амийн үг’ юм.

Сүнслэг дайчин болохынхоо хувьд сүнслэг дайнд орох зүтгэлтэн бол Бурханы үгийг сүнсээр зэвсэглэх ёстой юм. Энэ нь та Бурханы үгийг зөвхөн мэдлэг төдий ойлгох биш, Бурханы үг тушаалын дагуу амьдрах явдал юм. Тэгвэл та ямар ч айдасгүйгээр тулалдаж, сүнсээр хүчтэй болж, эр зоригтой байж чадна. Энэ дэлхийд амьдарч байгаа махан биеийн хүмүүс ч хүртэл шилдэг дайчин, илдээр тулалдагчид нь сэлэм нь өөрийн биеийн нэгэн хэсэг мэт байх ёстой гэж ярьдаг. Яг үүнтэй адил сүнслэг дайчин ч бас “Бурханы Үг” гэсэн илдийг биеийн нэгэн хэсэг мэт үйлддэг байх хэрэгтэй юм.

Нөгөөтэйгүүр “Бурханы Үг” нь олон хүмүүсийг сүнс сэтгэлийг хооллох амийн

хүнс тэжээл юм. Тиймээс Амос 8:11-д айлдахдаа “Талхаар өлсөх, усаар цангах биш, харин Эзний үгийг сонсохын төлөө өлсгөлөн байх болно” гэж айлдсан нь эцсийн үед биелэгдэх юм. Би Бурханд үй олон удаа мацаг барин залбирахад Бурхан Аав энэ сүмд “Таван Ариун Сайн Мэдээ”-г өгсөн. Тэр Өөрийн нандин үг сургаалуудаа үхэж, унтарч, уруудаж буй сүнснүүдийг дахин сэргээх босгон байгуулахын тулд мөн таныг сүнс сэтгэлээр өсгөж, ивээлийг хальтал өгөхийн тулд харамгүйгээр энэ сүмээр дамжуулан өгсөн билээ.

Үүнээс гадна, Ариун сайн мэдээ бол Бурханы үг гэдгийг батлахаар Тэрээр Өөрийн эрх мэдэлт хүч чадлыг ч бас өгсөн юм. Бурханы надад өгсөн Түүний эрх мэдэлт хүчээр тоо томшгүй олон тэмдэгт гайхамшигуудыг үйлдэж жинхэнэ цор ганц Бурхан оршин байдгыг батлан харуулсаар ирсэн билээ. Мөн түүнчлэн манай сүмд бол гал халуун залбирал, болон хүмүүсийг Ариун Сүнсний бялхам байдалд байлгаж, тэднийг итгэлээр өсгөхийн тулд ивээл дүүрэн магтан дуунуудаар аврал руу хөтлөх боломжтой билээ. Үүгээр ч зогсохгүй манай сүм гадаадад нийт 12 удаагийн Нэгдсэн их цуглаануудыг удирдан явуулж, үүгээр дамжуулан дэлхий дахинаа ариун сайн мэдээ тараах анхны арга замыг нээж чадсан бөгөөд Израйль улсад гулван жилийн турш үйлчлэл хийсэн. Мөн бид бүхэн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл болон телевизийн нэвтрүүлгээр дамжуулан



Бүтээгч Бурханы амьд оршин буйг ба зөвхөн Есүс Христ л бидний цор ганц аврагч мөн болохыг бүх дэлхий даяар зоригтойгоор тунхаглаж буй Доктор И Жей руг пастор. Библи бол жинхэнэ бодит үнэн гэдгийг баталсан тэмдэгт гайхамшигууд болон эрх мэдэлт хүчний үйлсүүд.

Доктор И Жей руг тэргүүн пастор нь Дэлхийн өнцөг булан бүрт гадаадын нэгдсэн их цуглаануудыг удирдан явуулж Библи бол жинхэнэ үнэн болохыг баталсан ба Бүтээгч Бурханы амьд оршин буйг ба зөвхөн Есүс Христ л бидний цорын ганц аврагч болохыг тунхаглаж байлаа.

Түүний залбирлаар сохор нь хараа орж, дүлий нь сонсож, хэлгүй нь ярьж, тахир дутуу хүн явж, үсэрч харайж байв. Маш олон төрлийн өвчин эдгэрч бүр хорт хавдар, ДОХ мэтийн эдгэшгүй, хүнд зэрэглэлийн өвчин хүртэл эдгэрлээ. Түүгээрч үл барам хар салхи алга болж, ган гачигаас болж зовж байсан орнуудад бороо хур орж ган тайлагдлаа. Үй олон агуу тэмдэг, гайхамшигууд болон эрх мэдэлт хүч гарч Бурханыг алдаршуулав.



Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг		Залбирлын цаг		
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Их мөргөл	Ням гариг 10: 30	Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40			
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00	Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00			
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30			
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30	Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773
www.manmin.org
www.manmintv.org

сүмийн мөргөлийг дэлхий даяар цацах боломжтой болсон.

Бурхан Аав маань манай сүмийг үй олон хүмүүсийн сүнснийг аврахын тулд энэ мэт хамгийн сайн багаж хэрэгсэл мэт хөгжүүлэн ерөөсөн билээ. Үүнийг дайны бэлтгэлтэй зүйрлэж байгаа ч энэхүү бэлтгэл нь эрхэм та маш сайн, олон төрлийн зэвсгүүдээр зэвсэглэхтэй л адилхан юм.

2) Хоёрдугаарт, Бурхан Аав маань итгэгчдийг сүнсээр өсөхөд тусласан.

Бурхан Аав маань эцсийн үеийн авралын зорилгоо бүрэн биелүүлэхийн тулд биднийг сүнсээр өсгөж тусласан юм. Тэрээр энэ нь ямар их чухал болохыг мэдээд 2010 оноос хойш асар хурдацтай сүнсний урсгал руу манай сүмийг замчилж өгсөн билээ. Өөрийн итгэлдээ үнэнч байж, итгэлээ харуулж чадсан хүмүүсийг асар их хурдацтай сүнсний урсгалд оруулж, итгэлийг нь маш сайн, хурдан өсгөж өгсөн.

Гэтэл мөн эсрэгээр нь маш олон гэм нүгэл хууль бус зүйлийг хийж, явдаг хүмүүс байсан. Тэр үед би тэдний хоньчины хувьд маш хүнд хариуцлагыг үүрч, гэм нүгэлээ гэмшиж, эргэхийн хүсэн итгэгчдийнхээ төлөө өөрийн амь насаараа дэнчин тавьж, өмгөөлөн, зуучлан залбирсан билээ. Тэгэхэд Бурхан Аав маань тэднийг нигүүлсэнгүй сэтгэлээр уучлан өршөөсөн бөгөөд сэтгэл санааны хувьд сүнсээр өсөх асар их хүсэн тэмүүлэх чин хүслийг тэдэнд төрүүлж өгсөн. Тиймээс 2011 онд олон итгэгчид өөрийн хүслээр Бурханы үг сургаалаар зэвсэглэж, баяр хөөр, аз жаргалтайгаар залбирдаг болсон.

2012 оны сүнсний урсгал нь 2011 оныхоос бага зэрэг өөр байсан. 2011 онд тэдний итгэл огцом өссөн ч харин 2012 онд маш удаан явцтай байсан. Энэ нь Бурхан Аав

маань тэднийг сүнсний урсгалаар удирдан замчилж байсантай холбоотой бөгөөд 2012 онд тэд өөрсдийн итгэлээрээ хүчийг олох хэрэгтэй байсан юм. Энэ нь Бурхан Аавын айлдсан үг аажуухан биелэгдэж буй мэт харагдаж байгаа нөхцөл байдал дотор итгэгчид хоньчныхоо үгэнд итгэх нь үү, эсвэл эргэлзэх нь үү гэдгийг Бурхан ажиглаж байсан юм. Энэ нь яг л Абрахам шиг ямар ч нөхцөл байдал үүссэн Бурханы амласан үгэнд хэзээ ч эргэлзэхгүй, байдаг шиг Бурхан Ааваас манай итгэгчдийг түүнтэй адил итгэлтэй болохыг хүсэж байгаа учир юм.

Мөн үүнтэй хамт итгэгчид хоньчинтойгоо хайраар нэгдэхийг хүсч байсан. Чин сэтгэлээсээ Бурханыг болон хоньчноо хайрладаг итгэгч бол хоньныхоо ачаанаас хуваалцах байхыг мөн хүсдэг. Сүм байгуулагдаад 30 жилийн туршид энэ 2012 он шиг итгэгчдийн зүрх сэтгэл нэгдэн, ойлголцож байсан удаа байгаагүй юм. Олон итгэгчид хүчээ нийлүүлж, зүрх сэтгэлээ нэгтгэж, чин сэтгэлээрээ хоньчны хүч болж байсан юм. 2012 он бол ивээл, ерөөлийн хур буусан он байлаа.

Бурхан Аав маань хүн бүрийн итгэл, найдвар ба хайрыг хэмжсэн бөгөөд түүнийх нь дагуу дээрээс сүнслэг итгэлийг дээрээс өгсөн юм. Түүний үр дүнд 2012 оны сүүлч хүртэл сүнсний, төгс сүнсний хүмүүс гарч ирэн, маш олон хүмүүс итгэлийн хадан суурийг өнгөрч, сүнс рүү ойрхон ирсэн билээ. Ялангуяа сүмийн ажилтнууд нь энэхүү сүнсний урсгал дотор хүчийг олсон юм. Тэд зүрх сэтгэл, сүнсээрээ нэгдэж, мэргэн ухааныг авч, хүнд хэцүүг даван туулсанаар одоо Канаан өргөө сүмийн цаг үед чухал үүрэг гүйцэтгэх, удирдан авч явах бүрэн чадвартай болж дасгалжуулагдсан билээ.

3. Аврал хүртсэн хүмүүсийн тоо нэмэгдэх сүнс зүгийн хууль.

Эцсийн үеийн авралын зорилго биелэгдэхэд хамгийн чухал нь сүнслэг хүмүүс илүү их олон болж, бид бүхэн гэм нүгэлгүй болох нь бүх хүмүүс аврагдаасай хэмээн хүссэн Бурханы хайрыг харуулж байгаа юм. Энэ нь Сүнс зүгийн гэрэл хурц байх тусам, харанхуйн хүч сул дорой болдог учраас юм. Тиймээс энэ сүмээр дамжуулан одооноос илүү олон хүн сүнслэг болж, сүнс талаасаа туйлыг харанхуй, гэм нүгэл, бузар булай, хорон муугаар дүүрсэн энэ дэлхийд гэрэлтэх хэрэгтэй болоод байгаа юм.

Эцсийн цаг үе ирэхэд хоньчинтойгоо хамтдаа сүнслэг хүмүүс төгс гэрлийг гэрэлтүүлэх болно. Үүний үр дүнд, гэм нүгэл дунд амьдарч байсан хүмүүст ч хүртэл аврагдах ерөөлтэй, боломж олдож байгаа юм. Та бүхэн сүнсний хүн, төгс сүнсний хүн болох тусам илүү олон хүмүүс аврагдах боломж олдоно гэсэн үг юм. Энэ нь сүнслэг урсгалын гол бодлого бөгөөд дүр төрх мөн.

Иймээс итгэгчид та бүхэн хожим өөрийн сүр жавхлан, тэнгэрийн орны шагналын төлөө төдийгүй олон хүмүүсийг аврахын төлөөх шударга байдлыг дүүргэхийн тулд сүнсрүү орох шаардлагатай болоод байна. Та бүхэн хоньчны золиос, зориулалт ба үйлчлэлээр авралын

боломжыг авч, сүнслэг урсгалд ивээл хүртсэн итгэгчид бөгөөд гүйцэтгэх хэрэгтэй билээ. Та бүхний хийх ёстой ажил бол өөрт оногдсон үүрэгт ажлаа хийж, сүнс рүү, төгс сүнс рүү орохын тулд хичээл зүтгэл гаргах хэрэгтэй. Тэгэж байж л ёс бус, бузар муу гэм нүглээр дүүрсэн харанхуй ертөнцөд үхэж буй хүмүүсийг харанхуйгаас нь гаргаж, гэрэл рүү дагуулах чадвартай болох юм. Үүний үр дүнд та эцсийн үед аль болох олон хүнийг аврах гэсэн Бурханы хүслийг биелүүлж чадах юм.

Хайрт итгэгч та бүхэн Шинэ онд өдрөөс өдөрт итгэлээр өсөж, сүнс рүү, төгс сүнс рүү орж эцсийн үеийн зорилгыг төгс биелүүлж, хожмын алдар ба сүр жавхлангын үед хамтдаа зогсохыг Их Эзэн Есүс Христийн нэр дээр залбирч байна!



Доктор И Жейруг тэргүүн пастор



2002 онд Энэтхэгт болсон Нэгдсэн их цуглаанд нийт 3 сая хүн оролцов



2003 онд Орос дахь Нэгдсэн их цуглаан



2004 онд Герман дахь Нэгдсэн их цуглаан



2004 онд Перуд болсон Нэгдсэн их цуглаан



2006 онд Конго Нэгдсэн их цуглаан



2009 онд Израйльд болсон Нэгдсэн их цуглаан



2012 онд Гил Тей шиг пастор нь сурган хүмүүжүүлэх ба Библи судлалын докторын зэргээр шагнагдсан бөгөөд бөгөөд тэрээр 10 гаруй жилийн турш гадаад улс оронд үйлчлэл хийсээр байгаа тул түүний хичээл зүтгэлийг нь хүлээн зөвшөөрч, өндөрөөр үнэлж, сайшаасан байна. Тэрээр эрх мэдэлт хүчит гар алчуураар (Үйлс 19:11-12) явсан газар болгондоо Ариун Сүнсний их тэсрэлт, мэт эрх мэдэлт хүчээр олон хүмүүсийг авралын зам руу замчилж Бурханыг алдаршуулсан юм.

“...Лалын шашинтай Пакистанд улсад сайн мэдээний үр таригдаж элбэг дэлбэг, арвин их үр жимсийг гаргах хүртэл...”

2000 оны 11-р сард Манмин Төв Сүмийн Тэргүүн пастор доктор И Жей руг пасторын удирдсан “Пакистаны Нэгдсэн их цуглаан” нь Лалын шашинтай Пакистан улсын Лахоре хотод болов. Төрөл бүрийн өвчтэй хүмүүс эдгэрч, 23 жилийн турш бузар муу сүнснүүдэд эзэмдүүлж байсан нэгэн хүнээс муу сүнснүүд нь хүртэл гарч явсан. Мөн түүгээр ч зогсохгүй үй олон эрх мэдэлт хүч гарч байлаа. Цаашлаад, зөвхөн Есүс Христ бол хүн төрөлхтөний цорын ганц жинхэнэ аврагч мөн гэж тунхаглагдсанаар олон хүн Есүсийг хүлээн зөвшөөрч, итгэгч болсон. Энэхүү Нэгдсэн их цуглаан нь лалын мусульман шашинтай оронд урьд өмнө нь болж байгаагүй Христийн маш том үйл ажиллагаа болж байна хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн.

Энэ Нэгдсэн их цуглааныг хараад миний зүрх сэтгэлд гал шатах мэт маш их хүсэн тэмүүлэлээр дүүрч, урам зориг орж байлаа. Доктор И Жей руг пасторын тарьсан энэ сайн мэдээний үрийг ургуулж, үр жимсийг

Пакистан болон Шри Ланкийн хүмүүс рүү хандсан Эзэний хайр

Гил Тей шиг пастор (Солонгосын Сөүл хот, Дэйжон Манмин сүм)

нь хураан авахад би туслах хэрэгтэй. Бурханы хүслийн дагуу хүмүүсийн зүрх сэтгэлийг би хэрэхэн, яаж өсгөж тэр жимсийг яаж ургуулах вэ? Түүнчлэн Эзэний бидний төлөө золиослосон үйлсийг хоосон болгохгүй нь тулд илүү олон хүмүүсийг Бурхан Аав руу замчилж Шинэ Иерусалимын жимс (иргэн) болгохын тулд мөн арвин их үр жимсийг гаргахын хүсэж буй Доктор И Жей руг пасторын сэтгэлийг би сэтгэл зүрхэндээ шингээн, өөрийн амийг өчүүхэн төдий ч хайрлалгүй Бурхан Аавын хүслийг биелүүлж буй түүнийг дуурайхын тулд хичээнгүйлэн залбирч байлаа.

Би Пакистанд нийт 14 удаа очиж, Пасторуудын семинар болон Эдгэрэл ивээлийн гар алчуурын цуглааныг Карачи, Исламабад, Азад, Кейшмир гэх мэт 12 мужид удирдан явуулж байсан. 2010 оноос хойш үйлчлэл хийх газраа өргөжүүлж Шри Ланкад хүртэл хийсэн бөгөөд энэ ажил маань их үр дүнтэй, ивээл дүүрэн, амжилттай сайн явагдаж байлаа.

Цаг мөч тутамд Галын дөл мэт нүдээр биднийг үргэлж хамгаалж байсан Бурхандаа бүх алдар магтаалыг өргөж байна.

Пакистанд аюултай газаруудаар явж байх үед биднийг үргэлж хамгаалж, ивээж байсан Амьд Бурхан Аавдаа бүх алдар магтаал, талархалыг өргөж байна.

2008 оны 11-р сарын 26 нд би Пакистан руу явж байхдаа Тай нисэх онгоцны буудалд буусан юм. Маргааш нь 11-р сарын 27 өдөр Тайландад засгийн газрын эсрэг жагсаалаас болж Тай нисэх онгоцны буудал хаагдсан билээ. Хэрвээ би Тай нисэх онгоцны буудалд нэг өдрийн дараа ирсэн бол Пакистанд хийх ажил үйлчлэл маань



хойшлогдох байлаа.

2009 оны 4-р сард би бүх ажилаа хуваарийн дагуу хийж дуусгаад Пакистанаас өглөө эрт үүрээр гарсан юм. Сүүлд нь мэдээ сонсоход Пакистанд тэр өдрийн өглөө намайг явсаны дараахан Талибаны эсрэг дайн зарласан байлаа. Би Бурхандаа талархаж Түүнд алдрыг өргөсөн юм.

Иймэрхүү байдлаар Талибаны хүч түрэмгийлсэн алан хядлага тасралгүй явагдаж байсан учраас Пакистаны үйлчлэл маш түгшүүртэй, үймээн самуунтай байсан ч Бурхан намайг үргэлж замчилж, удирдаж байсныг би мэдэрч байлаа.

2011 оны 5 сард Пакистаны үйлчлэлийнхээ дараа би Банконгд ирэх үед энэ үйл явдал болсон юм. Аль-Каидагийн үндэслэгч, удирдагч асан Осама Бин Ладенгийн үхлээс болж алан хядлага, болон заналхийлэлийн түвшин маш их өссөн гэж би сонссон. Гэвч бид Пакистан улсад 15,000 хүн оролцсон Нэгдсэн их цуглаанаа аль хэдийн хийгээд дуусчихсан байлаа. Энэ бүхэн бол зөвхөн Бурханы л ивээл ерөөл юм.

2012 онд би Пакистаны Хидерабад-д цуглаанаа хийгээд дараа нь Карачи-руу явсан. Орой нь намайг Карачид ирэхэд Пакистаны намын дарга нэгэн улс төрч алагдсан учраас Хидерабад-д жагсаал

болж баривчлага явагдаж байна гэж надад хэлсэн. Энэ жагсаалын үеэр хотын замын хөдөлгөөнийг хааж, бүх дэлгүүрүүд хаалгаа барьсан юм. Энэ үер 40 том оворын автобус шатсан гэж телевизээр мэдээлж байв. Хэрвээ энэ бүхэн зөвхөн нэг л өдрийн өмнө болсон бол би тэр цуглааныг Хидерабад-д хийх ямар ч боломжгүй болох байсан юм.

Шри Ланк, Пакистанд 400 орчим хамтран ажиллах болон салбар сүмүүдийг зөвшөөрч өгсөн Бурхандаа алдрыг өргөө.

Пакистанд одоогийн байдлаар Манмины 330 хамтран ажиллах болон салбар сүмүүд байдаг. Таван удаагийн үйлчлэлийн аялалаар Шри Ланкийн долоон хотод үйлчлэл хийж байх үед манай сүмийн 70 гаруй салбар болон хамтран ажиллах сүм бүртгэдсэн байсан. GCN (Жи си эн) телевиз, Доктор И Жей руг пасторын номууд, Урду хэл дээр орчуулагдсан Манмин мэдээ сонин, MIS (Манмины Олон Улсын Семинар) лекцүүд гэх мэт маш олон арга замаар Эзэний ажил амжилттай сайн ивээл дүүрэн явагдаж байна.

Тухайлбал, GCN (Жи си эн) телевизээр ариун сайн мэдээ болон эрх мэдэлт хүчийг Исаак телевизээр (Захирал: Анвар Фаззал пастор) цацаж, Доктор И Жей руг пасторын сургаалыг Англиар гурван удаа, Урду хэлээр гурван удаа нийт зургаан удаа өдөр бүр нэвтрүүлж байгаа бөгөөд Манмины урлагын тоглолтуудыг гаргадаг. Исаак телевиз бусад 253 кабелийн телевизтэй хамтран ажилладаг бөгөөд GCN (Жи си эн) телевизээр гарсан бүх хөтөлбөр 73 хотод цацагдаг.

Карачи гэх мэт 26 томоохон хотын Синдх муж хавийн бүх хүмүүс кабелийн телевизээр ариун сайн мэдээг сонсож байна. Мөн Ойрхи Дорнодод өдөрт наймаас илүү цагаар GCN (Жи си эн) телевизийн нэвтрүүлэг цацагдаж байгаа билээ.

Одоо Пакистан хүмүүс сүнсний хувьд асар их сэргэлтийг авч байгаа бөгөөд цаашдаа ч тэднийг Тэнгэрийн орны илүү сайхан газарт аваачихын тулд итгэлээр өсөхөд нь тэдэнд туслахыг би үнэхээр их хүсэж байна. Бүхий л алдар магтаал, талархалыг Бурхан Аавдаа өргөө.



Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган
Чуулганы утас: 976-11-351437
Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337
Е- шуудан: power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин